



**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.28

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны харьяа байгууллага болох Далайн захиргааны үйл ажиллагаанд хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Далайн захиргааны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 88.2%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Далайн захиргааны 2025 оны эхний хагас жилийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
52	88.3	36	1	4	-	3	2	6

Далайн захиргаа нь 2025 онд нийт 52 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 52 арга хэмжээнээс 100%-ийн хэрэгжилттэй 36 арга хэмжээ, 90%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, 70%-ийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 3, хэрэгжээгүй 2, хугацаа болоогүй 6 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 88.3 хувьтай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	Хугацаа	Биелэлт	%
1	2.2. Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх	2	II улирал	Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх үүднээс хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн хянан шалгагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулахаар гэрээний төсөлд санал авч хагас жилийн	0

				байдлаар 3 гэрээт хянан шалгагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулахаар санал солилцон ажиллаж байна.	
2.	5.13. Байгууллагын тайлан, танилцуулгын агуулга, загварыг сайжруулж нийтлэх	Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин /1-9 оноо/ 3	II улирал	Судалгаанд 25 ажилтан хамрагдсан ба дундаж үнэлгээ 6,72 оноогоор үнэлэгдсэн. Байгууллагын тайлан мэдээг monmarad.gov.mn сайтад тухай бүрд нь нийтэлж байгаа бөгөөд оруулсан мэдээ, тайланд ирүүлсэн гомдол саналгүй байна.	0
3.	2.5. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах баримт бичгийн бүрдлийг хүлээн авах, шалгах, хүсэлтийг шийдвэрлэх	II улиралд 20	II улирал	Тайлант хугацаанд нийт 17 иргэний тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг цахимаар хүлээн авсан бөгөөд ажлын хэсэгт ирүүлсэн баримт бичгийг хянан үзэж, шаардлага хангасан 8 иргэний хүсэлтийг, дүгнэлтийн хамт ЗТЯ-нд тус тус хүргүүлсэн.	30
4.	4.1. Далайн салбарын байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгүүдийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх	Санамж бичгийн тоо 4 Хөгжүүлсэн арга хэмжээний тоо 2	I-IV улирал	Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөлөг Онгоц Эзэмшигчдийн холбоотой хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Далайн Их Сургуультай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулсан.	30
5.	5.7. "Нэрийн ном"-ыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх	"Нэрийн ном"-ын нэвтрүүлэлтийн хувь 30	II улирал	Далайн захиргааны даргын 2024.11.25-ны өдрийн А/192 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, шаардлагатай судалгааг хийж гүйцэтгэсэн. Далайн захиргааны даргын 2025.02.27-ны өдрийн А/20 дугаар тушаалаар "Нэрийн ном"-ын жагсаалт батлагдсан. 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр "Луна Дизайн" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын албан ёсны "Нэрийн ном"-ыг боловсруулах	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

			ажлыг эхлүүлсэн. Нэрийн номонд тусгагдсан 28 ажлаас нэн тэргүүний 6 ажлыг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авахаар төлөвлөсөн боловч загвар баталгаажуулах үе шат хугацаа шаардсанаас үүдэн гүйцэтгэл хойшлогдсон бөгөөд одоо эхний шатны ажлыг баталгаажуулж, хүлээн авах бэлтгэл ханган ажиллаж байна.	
--	--	--	--	--

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
2	-	-	2	-	-

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
14	12	2	-	-	85.7

Хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Монгол-Солонгосын хамтарсан "Монгол Саммок Ложистик" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай 2025.02.11 А/33

2. Хамтарсан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэчлэн томилогдсон Монголын талын бүрэлдэхүүний талаар хамтрагч БНСУ-ын талд мэдэгдэж, холбогдох бүртгэлийг хийлгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Далайн захиргаа (Б.Сайнбаяр)-д

Биелэлт: Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн томилогдсон бүрэлдэхүүний бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулж байна.

2/ Монгол-Солонгосын хамтарсан "Монгол Саммок Ложистик" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай 2025.02.11 А/33

3. "Монгол Саммок Ложистик" ХХК-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай

Биелэлт: Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн томилогдсон бүрэлдэхүүний бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулж байна.

2.4 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
төсөв, гүйцэтгэл	14	4	1	-	-	9	94.0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	2	-	-	-	4	100.0



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

бусад	8	2	-	-	-	6	100.0
Нийт	28	8	1	-	-	19	96.7

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	хамааралгүй	
28	23	-	-	5	-	82.1

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1. 1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр

Биелэлт: - 0%

2. 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам

Биелэлт: Мэдээллийг тухай бүрт шинэчлэн оруулсан. 0%

3. 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам

Биелэлт: Мэдээллийг тухай бүрт шинэчлэн оруулсан. 0%

4. 2.6. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам

Биелэлт: Мэдээллийг тухай бүрт шинэчлэн оруулсан. 0%

5. 3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл

Биелэлт: - 0%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

Далайн захиргааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /1.3, 2.4, 3.4, 4.1, 6.2, 6.5, 7.1, 8.1-8.3, 9.2/

Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг 2025 оны эхний хагас жилд 100 гэрчилгээ олгохоор төлөвлөсөн боловч Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлсэн хөлөг онгоцонд нийт 686 бүртгэлийн гэрчилгээ олгосон нь төлөвлөлтийн үе шатанд шаардлагатай судалгаа, тооцоолол дутуу хийгдсэнээс үүдсэн төлөвлөлтийн алдаа болох нь харагдаж байна. Цаашид бодит хэрэгцээ, урьдчилсан тооцоонд тулгуурлан илүү нарийвчилсан төлөвлөлт хийх шаардлагатай байна.

Хэрэгжилтийн байдал:

1) Далайн захиргааны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 88.2%-тай байна.

2) Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог 2 байгууллагаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ч хамтран ажиллах сонирхол илэрхийлсэн хянан

шалгагчидтай гэрээний төсөл боловсруулах, санал авах, зөвшилцөх шат хэт сунжирсантай холбоотойгоор гэрээ байгуулах ажил удааширсан байна. Байгууллагын тайлан, танилцуулгын агуулга, загварыг сайжруулан нийтлэхдээ хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч хэрэгжүүлээгүй бөгөөд зөвхөн байгууллагын ажилтнуудыг хамруулсан нь зорилтот хэрэглэгчдийн бодит үнэлэмжийг тусгах боломжийг бүрдүүлээгүй. Үүний улмаас хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилтот түвшинд нийцээгүй гэж дүгнэлээ.

3) Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах баримт бичгийн бүрдлийг хүлээн авах, шалгах, хүсэлтийг шийдвэрлэх, Далайн салбарын байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгүүдийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй, хангалтгүй хэрэгжилттэй байна. "Нэрийн ном"-ыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх явцад загварыг баталгаажуулахад шаардагдах хугацааг урьдчилан төлөвлөөгүйгээс тус ажлын гүйцэтгэл хугацаа эхний хагас жилд багтаагүй хойшлогдсон байна.

4) Далайн захиргаа нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 52 арга хэмжээний хэрэгжилт 88.3% байна. Үүнээс 89.1% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 10.9% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

5) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт хувь
Зорилт 1: Далайн болон усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах	7	95.7
Зорилт 2: Далайн болон усан замын тээврийн үйл ажиллагааг чанаржуулах	5	57.5
Зорилт 3: "Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т тусгагдсан байршлуудад хуурай боомтыг үе шаттай байгуулах	7	91.4
Зорилт 4: Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, олон улсын хурал санаачлан зохион байгуулах	4	82.4
Зорилт 5: Монгол Улсын Далайн захиргааны хэвийн үйл ажиллагааг хангах	13	83.6
Зорилт 6: Байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах	5	94.0
Зорилт 7: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх	2	100.0
Зорилт 8: Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гарган, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	5	100.0
Зорилт 9: Салбарын хүний нөөцийг бэлтгэж, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	2	100.0



Зорилт 10. Далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн зөвлөгөөгөөр ханган дэмжлэг үзүүлж ажиллах	2	100.0
--	---	-------

6) Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/33 дугаар тушаалаар "Монгол Саммок Ложистик" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн томилсон. Тухайн тушаалд Монголын талын бүрэлдэхүүний талаар хамтрагч БНСУ-ын талд мэдэгдэж, холбогдох бүртгэлийг хийлгэх, мөн компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллах үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгажээ. Гэсэн хэдий ч энэхүү үүргүүдийн хэрэгжилт талуудын хооронд мэдээлэл солилцох ажиллагаа удаашралтай байгаагаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

7) Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

- 7.1. Далайн салбарын байгууллагуудтай шинээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгүүдийг байгуулахаас гадна байгуулагдсан санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулах;
- 7.2. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах;
- 7.3. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацаатай нь уялдуулж, үнэн зөв, монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, хоёр мянган тэмдэгтэд багтаан тайлагнаж хэвших;
- 7.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг бүрэн байршуулж, хөгжүүлэлт хийн, хоёр улирал дараалан хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн хянан шалгагчидтай байгуулах гэрээний төслийн талаар санал авах, хөгжүүлэлт хийх үйл явцыг шуурхай зохион байгуулж, санал солилцох ажиллагааг эрчимжүүлэх;

2. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч байгууллагын тайлан, танилцуулгын агуулга, загварыг сайжруулж, нийтлэх;

3. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах, сунгуулахтай холбоотой иргэдийн ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хүлээн авч, шаардлага хангуулах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн, шийдвэрлэх боломжийг эрэлхийлж, төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэн хэрэгжилтийг ханган ажиллах;

4. Далайн салбарын байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгүүдийг төлөвлөсөн хугацаанд нь байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр бодит ахиц гаргах;

5. "Нэрийн ном"-ын загварыг яаралтай баталгаажуулж, байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэн, үйл явцыг түргэвчлэх;

6. "Монгол Саммок Ложистик" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын шинэчилсэн бүрэлдэхүүнийг холбогдох байгууллагад мэдэгдэн бүртгэлжүүлэх ажлыг яаравчлан хэрэгжүүлэх;



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

7. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд монгол хэлний үг үсгийн алдаагүй, зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацаатай нь уялдуулан тайлагнаж хэвших,

8. Далайн захиргааны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн гүйцэтгэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ИТГЭЛТ

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА

Б.САЙНБАЯР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	52	46	88.3
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	2	-	ХБ
3	Сайдын тушаалын биелэлт	14	14	85.7
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	28	9	96.7
5	Ил тод байдлын үнэлгээ	28	28	82.1
Нийт		124	97	88.2

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:**

